

## “Нэг бүс, Нэг зам”-ын төсөлд Өвөр Монгол оролцох нь

Ч.Батцэцэг<sup>1\*</sup>

*Abstract: The paper aims to explore different views and perception of Inner Mongolian officials and academics on Inner Mongolian involvement in the project of The Silk Road Economic Belt or the build of the Belt and Road. The author focuses on the roles Inner Mongolia would play to link China, Mongolia and Russia and the mega projects Inner Mongolia would implement as enhancement to make the Northern Region of China open to the world.*

\* \* \*

Хятадууд эрт дээр үеэс “Торгоны зам”-ын дөрвөн төрлийн замыг нэрлэж, нэгд, “Элсэн цөлийн торгоны зам”, хоёрт, “Тал нутгийн торгоны зам”, гуравт, “Далайн торгоны зам”, дөрөвт, “Цайны эртний зам” хэмээж байв. Тэгвэл өнөөдөр БНХАУ нь “харилцан ашигтай, хамтдаа хожих” зорилгод тулгуурласан “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг (Silk Road Economic Belt) байгуулах төслийн ач холбогдлыг хөрш орнуудад сурталчлах ажлыг чухалчилж, зарим бүс нутагт эл төслийн ажлын эхлэлийг тавиад байна. БНХАУ-ын дарга Си Зиньпин 2013 оны 9, 10-р сард Казахстан, Индонези улсад айлчлал хийх үеэр “Торгоны замын эдийн засгийн бүс” болон “21-р зууны далайн торгоны зам”-ыг байгуулах хамтын ажиллагааны шинэчилсэн хэлбэрийн тухай санаачлагыг анх дэвшүүлсэн юм. (Цаашид энэ “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг “Нэг бүс, нэг зам” (The Belt and Road) гэж нэрийдэхээр болжээ.) Энэ хоёр санаачлага ялангуяа, “эдийн засгийн бүс”, “далайн зам” гэсэн үзэл баримтлал нь Хятадын өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогыг гүнзгийрүүлэх болон Хятад

---

1. \* ШУА-ийн ОУХХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) cbattsetseg@yahoo.com

улсыг эргэн тойрныхоо орнуудтай гадаад харилцаагаа урагшлуулахад чухал алхам болох тухай ХКН-ын 18 дахь удаагийн III бүгд хурал, ойр тойрны орнуудтай явуулах гадаад харилцааны ажлын тухай зөвлөгөөн болон эдийн засгийн ажлын талаархи Төв Хорооны хурал, зөвлөгөөний баримт бичгүүдэд тусгасны сацуу уг төслөөр хэлэлцүүлэг, хурал хийх, төслийн тухай гарын авлага танилцуулгыг англи, орос болон бусад хэлээр орчуулж хэвлэн тараах ажлыг идэвхтэй гүйцэтгэж байна.

Нөгөөтэйгүүр бүс нутгийн интеграци бол эдийн засгийн даяаршилд орох зайлшгүй үе шаг юм. Ази дахь бүс нутгийн хамтын ажиллагааг Европ, Хойд Америкийн хамтын ажиллагаатай харьцуулбал сайн хөгжөөгүй тал ажиглагддаг. Тиймээс ч Хятадын хувьд Азийн хөгжиж буй бүс нутгийн хамтын ажиллагааг бүгдийг холбож, бүс нутгийг энхийн замаар хөгжихөд хүчтэй түлхэц өгөх явдал чухал<sup>2</sup> хэмээн үзэж байна. Энэхүү “Торгоны замын эдийн засгийн бүс” нь хэдийгээр зүүнээс баруун тийш сунасан хэвтээ тэнхлэгийн “өргөн бүс” боловч босоо харилцаатай, газар зүйн хувьд энэ нь Төв Ази, Өмнөд Ази, Зүүн өмнөд Ази, Баруун Ази, Евроазийг хамарч байна. Одоогийн байдлаар, “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийн үндсэн гол хүч болох Төв Азийн орнууд Хятадын хооронд Туркменистанаас Узбекистан болон Казахстангаар дайраад Хятадад хүрэх газрын тос дамжуулах А болон В шугамыг байгуулж байна. Цаашид Туркменистанаас Киргизстан болон Тажикстанаар дайраад Хятадад хүрэх С болон D шугам баригдах аж. Үүн дээр нэмж, Хятад-Казахстаны газрын тос дамжуулах хоолой болон Хятад болон Киргизийн хооронд цахилгаан дамжуулах төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь нэн түрүүнд нэг “эрчим хүчний эдийн засгийн бүс”-ийг бүрэлдүүлэх гэсэн хандлага харагдаж байна.

Ийнхүү Хятад улс хөрш орнуудтайгаа харилцаагаа идэвхжүүлэхийн тулд зам тээвэр, автозам, төмөр замаар холбогдох, тээврийн хоолой хонгилыг улам олон салаа мөчиртэй болгох чиглэлийн бодлого баримталж, Евроазийн зах зээлийг Баруун Европын хотуудтай шууд холбох ажлуудын тухай “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Нэг бүс, нэг зам”-ын бүтээн байгуулалтын хүрээнд ярьж хэлэлцэх, зарим ажлын эхлэлийг тавьж байгаа тухай

---

2. [www.cpifa.org./user file/](http://www.cpifa.org/user file/)

дээр дурьдсан бөгөөд энэ төслийг хэрэгжүүлж бүтээн байгуулах эдийн засгийн бааз суурь ч Хятадад буй гэдгийг нэмж хэлэх нь зүйтэй байх.

Нөгөөтэйгүүр БНХАУ дотооддоо “Нэг бүс, нэг зам”-ыг тойрсон бүс нутгийн хөгжлийн стратеги болох Бээжин, Тяньжин, Хэбэйг хөгжүүлэх, Хөхмөрний эдийн засгийн бүс гэсэн гурван стратегийн бодлогыг чухалчлан хэрэгжүүлэх гэж байна. Энэ Бээжин, Тяньжин, Хэбэй гэсэн хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дотоодын олон бүсийг хамрах төдийгүй мөн Төв Ази, Зүүн өмнөд Ази, Өмнөд Ази, Баруун Азиар дайрч Европын хэсгийн бүс нутагт хүрч, бараг дэлхийн талыг хүрээлэх ажээ. Бээжин, Тяньжин, Хэбэй газар нутаг бол Хятадын эдийн засгийн хөгжлийн хамгийн хурдацтай хөгжиж буй бүс нутгийн нэг юм. Хятад улс баруун бүс нутгаа нээлттэй болгох, зүүн хойд нутгаа хөгжүүлэх, төвийн бүсийн хөгжлийг илүү түргэтгэх, зүүн бүсийн хөгжлийг урьдчилан төлөвлөх зэрэг хөгжлийн ерөнхий стратегийг цогцоор нь тасралтгүй хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа юм. Энэ тухай Хятадын Нийгмийн Шинжлэх ухааны академийн Эдийн засгийн стратегийн судалгааны газрын дарга, судлаач Гао Пэй хэлэхдээ: “Нэг бүс, нэг зам” хэмээх Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны хөгжлийн дагуу гадаадад нээлттэй байх шинэ стратеги нь Хятадын эдийн засгийн хөгжилд нэгэн шинэ индэр болж байна. Энэ нь Хятадын эдийн засгийн хөгжил болон хөрш орнуудын эдийн засгийн хөгжилд шинэ хөдөлгөх хүч болно. ”Хятадын оюун ухаан”-ыг харуулсан хөгжлийн ийм төслүүд нь олон улсад нээлттэй байх шинэ нөхцөл байдалд Хятадыг дэлхийд үгээ хэлэх эрхийг нэмж өгч байгаа юм” гэж тодорхойлсон<sup>3</sup> нь өнөөгийн Хятадын гадаад бодлогын үндсэн зорилгыг илэрхийлж байгаа юм.

БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэцян 2015 оны 3-р сарын 9-нд Бээжинд тавьсан “Засгийн газрын ажлын тайлан”-д дурьдахдаа, Хятадын хойд зүгийн том хаалгыг нээлттэй болгох үүднээс Өвөр Монголыг “Нэг бүс, нэг зам”-ын **стратегийн 16 мужид** багтаажээ. Улмаар Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь Хятад улсын хойд бүс нутгийг нээлттэй болгоход чухал гүүр болох, ойрын жилүүдэд Өвөр Монгол нь ихээхэн хүчин чармайлт гаргаж хойд бүсийг нээлттэй

---

3. Солонго сэтгүүл. 2015. 01

болгох талаар стратегийн арга хэмжээ авах, “Өвөр Монголын бүтээн байгуулалт нь нийт Хятадын хойд бүсийг нээлттэй болгох бэхлэлт хийх болон хил орчмын эдийн засгийн бүсийн төлөвлөгөө”-г баталсан байна. Мөн Эрээн хот, Манжуурын гол чухал нээлттэй туршилтын бүсийг байгуулах ерөнхий төлөвлөгөөг гаргаж, Өвөр Монгол дахь улсын Хөгжил шинэчлэлийн хорооны ажлын хэсгийг батлан, 2015 оноос эхлэн Өвөр Монголд жил бүр 1,5 тэрбум юанийг хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтанд зарцуулахаар хуваарилжээ.<sup>4</sup>

Өвөр Монголын Өөртөө Засах Орон /ӨМӨЗО/ нь газар зүйн байршлын хувьд Хятадын хойд хэсэг, зүүн хойд хэсэг, баруун хойд хэсгийг хөндөлсөн байрладаг. Монгол Улстай 4600 км газраар, ОХУ-тай 4200 гаруй км газраар тус тус хиллэдэг нь тэдгээр оронтой Хятадын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд давуу талтай, тиймээс ч Баруун бүсийн хөгжлийн стратегийн төсөлд багтаж байсан. Одоо мөн “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Нэг бүс, нэг зам”-ын дотоодын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төсөлд ийнхүү хамрагдаад байна. 2015 оны 1-р сарын сүүлээр Хөх хотод хуралдсан БНХАУ-ын ӨМӨЗО-ы АТИХ-ын 12 дахь удаагийн III чуулган дээр ӨМӨЗО-ы тэргүүн Баатар “Засгийн газрын ажлын тайлан-”д: “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Нэг бүс, нэг зам”-ын бүтээн байгуулалтын хүрээнд тус Өөртөө засах орон /ӨЗО/ багтсан нь Хятадын хойд бүс нутгийг нээлттэй болгох гүүрийн (хятадаар бэхлэлт-цайз гэж бичиж буй-зохиогч) үүргийг гүйцэтгэх бүтээн байгуулалтыг урагшлуулах чухал алхам боллоо.”<sup>5</sup> Улмаар Өвөр Монгол нь гадаадад нээлттэй байх бодлогын түвшинг бүхий л талаар дээшлүүлэх, Орос, Монголтой харилцаж бодитой хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, Манжуурын гол нөөцийг нээн хөгжүүлснээр нээлттэй туршилтын бүс болгох бүтээн байгуулалтанд түлхэц өгөх, Эрээн хотын гол онцлогийг чухалчлан нээн хөгжүүлж, нээлттэй туршилтын бүс болгох асуудлаар Төрийн зөвлөлийн зөвшөөрлийг авсан<sup>6</sup> тухай тусгажээ.

Ийнхүү Өвөр Монгол “Нэг бүс, нэг зам”-ын төсөлд багтаж, хил залгаа хөрш орнуудтай хамтран ажиллах боломжийн талаар

4. <http://china.huanqiu.com/hot/2015-03/5869790.html>

5. <http://www.chinanews.com/df/2015/01-26/7004841.shtml>

6. <http://www.chinanews.com/df/2015/01-26/7004841.shtml>

Өвөр Монголын холбогдох албаны зарим хүмүүсийн үзэл бодол, дэвшүүлсэн саналаас эш татвал: ӨЗО-ы дэд дарга Дун Хэнюй хэлэхдээ, “Өвөр Монгол нь “Нэг бүс, нэг зам”-ын хөгжлийн стратегид багтаж, бид хилийн боомтын эдийн засгийн байдалд зохих судалгааг хийсэн, ойрын жилүүдэд хил орчмын боомтын хөгжил харьцангуй хурдан байгаа, Си Зиньпин дарга Монгол, Орост айлчилж олон гэрээ хэлэлцээр хийж хоёр талын харилцааг бэхжүүллээ.” Мөн улсаас “Нэг бүс, нэг зам” стратегийн талаар авч буй арга хэмжээ нь Өвөр Монголыг гадаадад нээлттэй байх бодлогыг урагшлуулахад хурдаа нэмж шинэ боломжийг бий болгож байна” гэжээ. Хөх хотын Төмөр замын товчооны дарга Фэй Дунбин: “одоо Монгол Улсын төмөр замыг Эрээн хотын боомттой холбох, бусдыг нь одоогоор урагшлуулж байна энд Мандал, Ганцмодны боомтыг багтааж байна. XIII таван жилийн төлөвлөгөөг батлахдаа энэ асуудлыг хөндөж улсын холбогдох яам дахин батлах тохиолдолд бид зорчигчийн болон шууд хүрэх түргэн галт тэрэгний сүлжээтэй болох, хоёр талаасаа бүгд “Нэг бүс, нэг зам”-д шууд орох төмөр замын тухай ярьж хэлэлцэх бөгөөд энэ өөртөө засах орны эдийн засгийн хөгжил нь бүгдэд ашигтай байх болно.” Хэдийгээр энэ нь боломж ч гэсэн бас өрсөлдөх л болно. Хөлөнбуйр аймаг Монгол, Орос улстай залгадаг, 2014 онд 12 сая 930 мянган жуулчин хүлээн авч, аялал жуулчлал 3.6 тэрбум орлого оруулсан боловч гадаадад аялсан жуулчдын тоо 550 мянга байна. Дотоодын аялал жуулчлалыг хэрэгжүүлэхээс гадна Хөлөнбуйрт гадаадын жуулчдыг татах хэрэгтэй байна. Ялангуяа Орос, Монголын жуулчдыг оруулах ажлыг хийх болно” гэжээ. Мөн түүнчлэн Хөлөнбуйр хотын дарга Жан Липин хэлэхдээ, “цаашид энэ гурван газрын аялал жуулчдын хамтын ажиллагаанд урьдын адил маш том орон зай байна. “Хөлөнбуйр болон Монгол Улсын хооронд одоогоор төмөр замаар хараахан холбогдоогүй, автозам манай хилийн дотор буй, гэхдээ Монгол Улс мөн л талын замтай, зөвхөн замаар холбогдох хэрэгтэй, хоёр улсын хоорондын аялал жуулчлалыг маш тохиромжтой хөгжлийн эхлэл бий болж байна.”<sup>7</sup>

Өвөр Монголд улсын чанартай гадаадад нээлттэй 16 боомт байдаг нь бүх Хятадын хэмжээнд нэлээд олон томоохон боомттой, мужийн

7. <http://china.huanqiu.com/hot/2015-03/5869790.html>

нэгд тооцогддог. Өнөөгийн байдлаар, БНХАУ болон ОХУ-ын хуурай замын бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 65%, БНХАУ, Монгол Улсын хуурай замын бараа бүтээгдэхүүний 95% нь Өвөр Монголын Өөртөө Засах Орны боомтуудаар дамждаг. 2014 оны эхний найман сарын байдлаар, Өвөр Монголын боомтуудын экспорт, импортын бараа тээвэрлэлтийн хэмжээ 40.715 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээсээ 5.1%-иар нэмэгдсэн байна.<sup>8</sup>

Өнгөрсөн 2014 оны байдлаар, Өвөр Монголын гадаад худалдааны экспорт, импортын нийт дүн 14.55 тэрбум ам долларт хүрч, 21.4%-иар нэмэгджээ. Тухайлбал, сүүлийн жилд Эрээн хотын дэд бүтцийн бүтээн байгуулалт харьцангуй сул байгаа бодит байдалд үндэслэн 2 тэрбум юаний хөрөнгө оруулалт хийж, Эрээний онгоцны буудал, автозамын боомтын ачаа тээврийн шинэ нэвтрэх зам, автозамын боомтын жуулалын гаалиар нэвтрэх зам, мөн автозамын ачаа тээврийн тусгай шугам зэрэг нэг хэсгийн гол барилгын ажлыг хэрэгжүүлж, боомтын хөгжлийн хүнд тоног төхөөрөмжийн бүтээн байгуулалтын нөхцлийг өөрчлөн сайжруулсан байна.<sup>9</sup>

БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 оны 8-р сард Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр, хоёр тал боомт, төмөр замын хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх тухай нэгдсэн ойлголтонд хүрсэн төдийгүй хоёр талын валют солилцооны цар хүрээг тэлж 15 тэрбум юаньд хүргэхээр тохиролцсон юм. Мөн Монгол Улсын Замын-Үүд, БНХАУ-ын Эрээн хот зэрэг газруудад хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах асуудлыг судлахаар тохирч, ашигт малтмалыг сайн боловсруулах, шинэ эрчим хүч, цахилгаан эрчим хүч, хөдөө аж ахуй, байгаль экологи зэрэг салбарт бүх талын хамтын ажиллагааг өрнүүлэхээр болсон билээ. БНХАУ нь Монгол Улсын томоохон экспорт, импортын томоохон түнш улс болж, 15 жил дараалан манай улсын худалдааны хамгийн том түнш болж, хоёр талын худалдааны хэмжээ 2003 онд 440 сая ам доллар байсан бол арван жилийн дараа 2013 он гэхэд 6 тэрбум ам доллар болон нэмэгджээ.

Нөгөөтэйгүүр 2015 онд Хятадын гадаадад нээлттэй байх бодлоготой холбогдуулан Өвөр Монгол нь “Нэг бүс, нэг зам”-ын

8. Солонго сэтгүүл. 2015. 01

9. Солонго сэтгүүл. 2015. 02

төслийн хүрээнд авах арга хэмжээ, Бээжин, Тяньжин, Хэбэйг хөгжүүлэх, Хөхмөрний эдийн засгийн бүс гэсэн гурван стратегийн энэхүү боломжийг ашиглан Өвөр Монголын хөгжлийн стратегид зохицуулан тодорхойлж, улсынхаа хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах, улсынхаа стратеги дэх хөгжлийн орон зайг хангахын тулд сайтар ажиллахаар болсон тухай Өвөр Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр мэдээлж байна.<sup>10</sup> Өвөр Монгол нь “Нэг бүс, нэг зам”-ын бүтээн байгуулалтын төсөл боловсруулж, Хятадын хойд бүс нутгийг нээлттэй болгох талаар шат дараалсан арга хэмжээ авахаар болжээ. Тухайлбал, 2014 он бол “Нэг бүс, нэг зам”-ын стратегийг байршуулах эхний жил гэж үзээд, 2015 онд Өвөр Монгол энэ боломжийг ашиглан дэлхийн өнцөг булан бүрт “харилцаа холбоо” тогтоох ажлыг эхлүүлэн гүнзгийрүүлэх, улс орон, бүс нутаг бүхэнтэй эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэхээр болсон байна. Мөн түүнчлэн Бээжингээс харьцангуй ойр байрлалтай хотуудын нэг болох Хөххотыг “Бээжин, Тяньжин, Хэбэй стратегийн төсөл”-ийн бүтээн байгуулалттай хэрхэн уялдуулах талаар Хөх хотын дарга Тай И БХАТИХ-ын 12 дахь удаагийн 3-р бүгд хурал дээр санал дэвшүүлэв.<sup>11</sup> Тэрбээр: нэгд, улсынхаа холбогдох яамдыг идэвхтэй дэмжих, Хятад, Монголын хамтарсан үзэсгэлэн яармагийг түргэн хугацаанд Хөххотод зохион байгуулах, тэгснээр Өвөр Монголыг гадаад нээлттэй байх нэр хүндийг өсгөх; хоёрт. Хубэй, Бугат, Ордосын хотын бүтээн байгуулалтын цогцолборыг Бээжин, Тяньжин, Хэбэй төслийн ерөнхий төлөвлөгөөнд оруулж тусгах тухай. Бээжин, Тяньжин, Хэбэй бол байгаль экологи, аялал жуулчлал, далайн хотын цогцолборын гол цөмийн нэг. Эдгээр Хубэй, Бугат, Ордос нь тус ӨЗО-ы баруун хэсгийн хотуудын цөм, улсынхаа гуравдугаар зэрэглэлийн түвшинд цогцлон байгуулагдсан хот болно. Энэ хоёр бүс харилцан бие биенээ нөхөх чадвартай, тухайлбал, Хөххот нь Бээжингийн харилцаа холбоо, банк санхүү, цахим арилжаа, засаг захиргааны болон аж ахуйн нэгжийн томоохон төв зэрэг арын үйлчилгээний төрлийн үйлдвэрлэлийг эргэлтэнд оруулах ажлыг гүйцэтгэхэд маш тохиромжтой, шинжлэх ухаан технологийн үр дүн үйлдвэрлэлийг боловсруулах эргэлтэнд оруулах төрөл зүйлийг гүйцэтгэх. Хөххот, Бээжин, Тяньжин, Хэбэй гаалийн татвараас үр тарианы нөөцийг чөлөөлөх анхан шатны боловсруулалт

10. [http://www.xbfw.com.cn/news/xwj/2013-11-28/64776\\_2.html](http://www.xbfw.com.cn/news/xwj/2013-11-28/64776_2.html)

11. <http://gov.nmgnews.com.cn/system/2015/03/06/011639931.shtml>

хийх зэрэг технологийн хамтын ажиллагааг цогцоор нь нийлүүлэх, үүний зэрэгцээ Бээжин, Тяньжин, Хэбэйн бүс нутагт хөдөө аж ахуй, мал аж ахуйн чанартай шилдэг бүтээгдэхүүн болон экологийн цэвэр эрчим хүчээр хангах зэрэг үйлчилгээгээр хангах нөөц бололцоотой<sup>12</sup> ажээ. Ийнхүү Өвөр Монголын гадаадад нээлттэй байх хөгжил нь Хятадын хойд бүсийг нээлттэй болгох хөгжлийн томоохон загварын хамгийн чухал хэсэг болж байна.

Өвөр Монгол нь 2000 онд Хөххот, Бугат, Ордос хэмээх газрын эдийн засгийн онцгой тойргийн бүтээн байгуулалтыг хөгжлийн гол стратеги хэмээн тодорхойлж, Өвөр Монголын “алтан гурвалжин” хэмээн алдаршуулсан нь тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд асар их үүрэг гүйцэтгэх болов. “Өвөр Монголын энэ Хөххот, Бугат, Ордосын нутаг дэвсгэр болон Монгол Улсын өмнөд бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг шууд хөдөлгөөнд оруулах чухал ач холбогдолтой”<sup>13</sup> хэмээн хятадын судлаачид үзэж байна. Сүүлийн үед ӨМӨЗО-ны хойд хилийн дагуу эрчим хүчний болон уул уурхайн аж үйлдвэрүүдийг цогцоор нь барьж байгуулж байна. Жишээлбэл, зөвхөн ӨМӨЗО-ны Баяннуур хот буюу шинээр нээхээр төлөвлөөд байгаа Бага модны боомт орчимд гэхэд л таван сая квт-ын хүчин чадалтай эрчим хүч үйлдвэрлэх хоёр ч цахилгаан станц байгуулжээ.

Нөгөөтэйгүүр манай улсын түүхий эд Монгол, Хятадын хилээр Өвөр Монгол руу болон Хятадын бусад нутаг руу нэвтрүүлэх 12 цэгээр гарч байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.5-д “Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно” гэж заасан байдаг. Өнөөгийн Хятадын хурдацтай хөгжилд нэг талаас Монголын түүхий эдийн нөөц маш их хэрэгтэй болж байгаа, нөгөө талаас манай улс эдийн засгийн хямралаас гарахын тулд Хятадтай харилцан бие биенээ нөхөх давуу байдлыг ашиглан харилцан ашигтай, хамтаар хожих боломжтой юм.

12. 《内蒙古日报》全国两会全媒体报道组记者 魏那. Өвөр Монголын өдрийн сонин.

13. Ли Те, Юй Сяо. “Хятад, Монголын дэд бүтцийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх нь, Шинэ торгоны замын эдийн засгийн бүсийг бүрэн төгс байгуулах нь.” Илтгэл. ЗХА-ийн форум. 东北亚论坛2014年第2 期

Эцэст нь Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Нэг бүс, нэг зам” хэмээх энэ санаачлагын уриалгыг дэлхийн улс орнууд ялангуяа хамрагдах бүс нутгийн орнууд янз бүрээр хүлээн авч байна. Тухайлбал: зарим нь энэ хөтөлбөрийг өөртөө ашигтайгаар харж дэмжих, хөтөлбөрт идэвхтэй оролцох, хөрөнгө оруулалтаар улс орноо хөгжүүлэх бодлого зорилготой байгаа бол хөрш орнууд Хятадаас болгоомжлох, эсэргүүцэх, хэрхэн оролцож шийдвэрлэхээ сайн тогтож төлөвлөөгүй байдал ажиглагдаж байна. Анх БНХАУ-ын дарга Си Зиньпин энэ “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийн үзэл баримтлалыг дэвшүүлэхдээ, энэ төслийн гол зорилго нь хамтын ажиллагааг хөгжүүлэх, тэгэхдээ улс төр, тээвэр, худалдаа, мөнгө санхүүгийн харилцаагаар баяжуулан амьдралд хэрэгжүүлэх болон ард иргэдийн хоорондын хүмүүнлэгийн яриа хэлэлцээг бэхжүүлэх хэрэгтэй гэж хэлсэн байдаг.

Монгол Улсын хувьд манай төр засгийн тэргүүн нар БНХАУ-ын санаачилсан “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийн төслийг дэмжиж, Монгол Улс нь Ази Европ тивийн зааг дээр оршиж төмөр зам, автозам зэрэг зам тээврээр дамжин Хятад болон Европын олон улсыг холбодог, тиймээс энэ төслийн бүтээн байгуулалтанд идэвхтэй оролцоно хэмээн амлаж, уг төсөлд “Талын зам” гэсэн төслөөр оролцохоо илэрхийлсэн байдаг. Мөн “Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк”-ны гишүүн орон болсон юм. Гэвч өнөөгийн байдлаар Монгол Улс уг төсөлтэй хэрхэн яаж холбогдох нөхцөл байдал, ямар боломж байгаа талаар яриа хэлэлцээг үргэлжлүүлэн, цаашид бодитоор судлах болно гэсэн хэмжээнд л байгаа бөгөөд энэ чиглэлд дорвитойхон ахиц гаргаагүй байна. Мэдээжийн хэрэг, энэ төслийн хүрээнд Евроазийн асар өргөн уудам орон зайд шинэ зах зээл байгуулах, тэдгээрийг холбосон дэд бүтэц, ялангуяа өндөр хурдны төмөр зам барих нь сонирхогч бүх улсуудын хөгжил дэвшилд хүрэх хамгийн дөт зам болох нь тодорхой. Нөгөөтэйгүүр Монгол Улс Хятадын “Нэг бүс, нэг зам”-ын төсөлд орохдоо зөвхөн ӨМӨЗО-той холбогдоод зогсохгүй баруун зүгт Синьзян-Уйгурын Өөртөө Засах Оронтой уг төслийг хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Үүний тулд Монголын зүүн, барууныг холбосон төмөр зам барьж улмаар Хятадын Синьзян-Уйгурын Өөртөө Засах Орон, Казахстан, Узбекистан, Туркменстанаар дайран Туркийн Станбул хүрэх Евроазийн тээврийн шинэ хонгил байгуулах боломжтой. Тэгснээр

Монгол Улсыг Евроазийн эдийн засгийн хөгжлийн шинэ орон зайд нэгтгэх гол гарц болох талтай. Казахстан-Синьзян Уйгурын Өөртөө Засах Орны хилийн боомт “Хоргос” нь манай улстай дөт замаар холбогдох учир Хятадын Синьзян -Уйгурын Өөртөө Засах Орон-Казахстан-Оросыг холбосон төмөр замыг ч идэвхтэй ашиглах боломж бий. “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг хөгжүүлснээр худалдааны урсгалыг нэмэгдүүлж, улс орнуудын эдийн засгийг тэнцвэржүүлэх, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх болно.

Энэ “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг дэмжих гол түлхүүр салбарын нэг бол аялал жуулчлалын салбар юм. Тиймээс ч олон улсын хамтын ажиллагаа нь аялал жуулчлалаар дамжуулан улс, үндэстнүүдийн хооронд найрсаг харилцааг бий болгодог. Энэ салбарыг хөгжүүлэхэд дэд бүтэц төмөр зам, авто замын бүтээн байгуулалт зайлшгүй хэрэгтэйгээс гадна уг төслийг хэрэгжүүлэхэд хөрш орнуудын харилцан итгэлцэл хамгийн чухал байх болно.